



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/35/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Дорноговь аймаг)

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас:7052-2734

Цахим хаяг:

dornogovi@audit.dov.mn

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас:7035-2030

Цахим хаяг:

Аудитор:

М.Мөнхнаран

Утас:99352464

Цахим хаяг:

mnbaudithhk@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.10	Шилэн дансны мэдээлэл.....	12
2.11	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.12	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3	Менежментийн захидал	13
3.1	Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт	14

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ЛАБОРАТОРИ НЭГДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ТАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ГҮЙЦЭТГЭЛТ ҮЙЦЭТГЭН
ДЭГСҮРЭНХҮҮ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 9.9.1 т заавраар дагуу Замын Үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусаар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан андаа, зөрлийг эс тооцвол Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн гүл хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн төмөөхон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал:

1. Нийт Хоол, урсгал зардал, хичээл үйлдвэрлэлийн зардал гэсэн 3 төрлийн зардлаас зарцуулалт хийхдээ нийт 85,745,4 1 мянган төгрөгийн худалдан авалтыг

хийхдээ шууд гэрээ байгуулан худалдан авалтыг хийсэн нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2 дахь заалт, 24.4. "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Сангийн сайдын 2013 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан Цахим тендер зохион байгуулах журам, Засгийн газрын Босго үнэ шинэчлэн батлах тухай 2013 оны 68 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 24 тогтоолоор батлагдсан журмын 9.1.1 " төсвийн жилийн эхэнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон батлагдсан төсвийг хэрхэн зүй зохистой удирдаж авлага, өр төлбөр шинээр үүсгэхгүй байх талаар төлөвлөгөө гаргаж мөрдүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. 6267.2 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг нотлох баримтгүйгээр Төсвийн байгууллага болон хувийн байгууллагад шилжүүлсэн, 2017 онд үүссэн 10577.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 39.4.2 "өр, авлага үүсгэхгүй байх", Төрийн сангийн төлбөр тооцооны журмын 5.7 " төсвийн байгууллага нь төлбөрийн хүсэлтийг үндэслэх баримтын хамт ирүүлэх үүргийг хүлээнэ. Үндэслэх баримтад амлалтын зөвшөөрөл, байгуулсан гэрээ хэлцэл, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан акт, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын падаан эсвэл өр төлбөр байгааг нотолсон бусад бичиг баримт хамаарна. Хуулийн дагуу тендер шалгаруулж, бэлтгэн нийлүүлэгчийг сонгосон бол тендерийн хорооны хуралдааны тэмдэглэлийг хавсаргана" заалт тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын төвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Сүрэнхүү-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.25-наас 2019.02.18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын гэрээгээр “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдрийн 020 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль нь Замын-Үүд сумын бүрэн дунд боловсрол эзэмших хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ хүүхдийг зөв хүн болгон төлөвшүүлэх, Дорнын их говь нутгийн гэрэлт ирээдүй өсвөр үеэ амьдрах арга ухаанд сургах, хүмүүнлэг оюунлаг иргэд болгох гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

(Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа)-р Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын нэг буюу хэд хэдэн төвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- УСНББОУС стандарт

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд (нийцсэн) байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд (Бага) гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөтэй) гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 1 хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Тус байгууллага нь өөрийгөө санхүүжүүлдэггүй төсвийн санхүүжилтээр төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэгтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны *Нийт зардал* 1.745.214.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 17,452.14 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 0 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	6,267.20	
3	Албан шаардлага өгсөн	2	96,322.50	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	102,589.70	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

Хоол, урсгал зардал, хичээл үйлдвэрлэлийн зардал гэсэн 3 төрлийн зардлаас зарцуулалт хийхдээ нийт 85,745,4 1 мянган төгрөгийн худалдан авалтыг шууд хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан тухай хууль, сангийн сайдын 2013 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан цахим тендер зохион байгуулах журам, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 9.2 " 9.2.1, 9.2.2 -д зааснаас бусад төлбөрүүдийг амлалт үүсгэлгүйгээр гүйцэтгэж болно" гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгч биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 25 дотор Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг санал болголоо.

2.8.1.2. Балансын данстай холбоотой асуудал

1. 6267.2 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг нотлох баримтгүйгээр Төсвийн байгууллага болон хувийн байгууллагад шилжүүлэн авлага үүсгэсэн байна.

2. 2017 онд үүссэн 10577.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” , 39.4.2 “өр, авлага үүсгэхгүй байх” , Засгийн газрын 2015 оны 24 тогтоолоор батлагдсан журмын 9.1.1 " төсвийн жилийн эхэнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон батлагдсан төсвийг хэрхэн зүй зохистой удирдаж авлага, өр төлбөр шинээр үүсгэхгүй байх талаар төлөвлөгөө гаргаж мөрдүүлнэ" , Төрийн сангийн төлбөр тооцооны журмын 5.7 " төсвийн байгууллага нь төлбөрийн хүсэлтийг үндэслэх баримтын хамт ирүүлэх үүргийг хүлээнэ. Үндэслэх баримтад амлалтын зөвшөөрөл, байгуулсан гэрээ хэлцэл, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан акт, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын падаан эсвэл өр төлбөр байгааг нотолсон бусад бичиг баримт хамаарна. Хуулийн дагуу тендер шалгаруулж, бэлтгэн нийлүүлэгчийг сонгосон бол тендерийн хорооны хуралдааны тэмдэглэлийг хавсаргана " заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Төсвийн байгууллага болон хувийн байгууллагад шилжүүлэн авлага үүсгэсэн 6267.2 мянган төгрөгт төлбөрийн акт
2. 2017 онд үүссэн 10577.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авах талаар албан шаардлага өгч биелэлтийг акт, албан шаардлагад тавигдсан хугацаанд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг санал болголоо.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Ажлын байрны бүтэц орон тоо батлагдсан хэмжээнд байгаа эсэхийг үзэх шаардлагатай.

Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой (11) хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,617,641,8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,559,289,2 мянган төгрөг буюу (96) хувьтай байгаа нь бусад урсгал шилжүүлэгийн зардлын хэмнэлтээс шалтгаалжээ.

2.10 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.12 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

Илрүүлэлт

Төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийхдээ зарим ажил гүйлгээний анхан шатны баримтад худалдан авалтыг баталгаажуулсан Е баримт хавсаргаагүй байна. Энэ нь НББ тухай хуулийн 13 дүгээр зүйл Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн ААН байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврыг /НХМ-ТМ-5/ тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Е баримтыг худалдан авалт хийсэн ажил гүйлгээ бүрд анхан шатны нотлох баримтаар авч баримт бүрдүүлэлтийг сайжруулах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн Нягтлан бодогч Ц.Эрдэнэчимэг

Эрсдэл

1. Бүртгэлээр тавих хяналт алдагдана.
2. Татварын орлого бүрдүүлэлт, тайлагнал дутуу илэрхийлэх боломж бүрдэнэ.

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 16-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад (2019 оны 12 дугаар сарын 25)-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Ч.АРИУНАА

Ц.ЛҮНДЭГМАА

М.МӨНХНАРАН

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
4.1 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>228,059,334.17</u>	<u>145,433,806.57</u>
33	АВЛАГА	54,942,672.31	17,176,063.39
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	10,801,742.31	538,222.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	246,900.00
335	Бусад авлага	44,140,930.00	16,390,941.39
3351	Байгууллагаас авах авлага	43,075,012.00	16,325,023.39
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,065,918.00	65,918.00
35	БАРАА МАТЕРИАЛ	173,116,661.86	128,257,743.18
351	Түүхий эд материал	45,653,982.94	27,690,257.94
35110	Тусгай зориулалттай материал	45,653,982.94	27,690,257.94
35300	Бэлэн бүтээгдэхүүн	27,444,569.11	26,102,436.11
354	Хангамжийн материал	100,018,109.81	74,465,049.13
35420	Аж ахуйн материал	56,748,896.89	52,884,863.21
35440	Түлш, шатах тослох материал	00.00	40,000.00
35460	Хүнсний материал	4,082,694.00	4,118,730.00
35470	Бусад хангамжийн материал	38,959,176.92	17,194,113.92
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,422,525,734.78</u>	<u>3,846,978,885.80</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,422,525,734.78	3,846,978,885.80
392	Биет хөрөнгө	1,422,190,681.02	3,632,088,885.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,478,376,147.00	5,117,745,676.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,271,754,829.38	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	380,694,849.27	408,666,721.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-225,398,268.25	-244,495,049.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	148,198,409.82	267,674,196.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-116,586,044.17	-126,112,467.42
39215	Хуримтлагдсан элэгдэл	-58,385,319.69	-60,767,806.78
393	Биет бус хөрөнгө	335,053.76	214,890,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,392,744.24	-2,727,798.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	214,890,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,650,585,068.95</u>	<u>3,992,412,692.37</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>296,740.00</u>	<u>1,202,756.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	296,740.00	1,202,756.00
413	Өглөг	296,740.00	1,202,756.00
4136	Бусад өглөг	296,740.00	1,202,756.00
41361	Байгууллагад төлөх өглөг	296,740.00	1,202,756.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,650,288,328.95</u>	<u>3,991,209,936.37</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,650,288,328.95	3,991,209,936.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,362,808,149.51	1,577,698,149.51
51101	Өмч: - төрийн	1,362,808,149.51	1,577,698,149.51
512	Хуримтлагдсан үр дүн	-250,892,107.25	-327,194,909.96
51210	Өмнөх үеийн үр дүн	-250,892,107.25	-251,002,917.25
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-76,191,992.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	538,372,286.69	2,740,706,696.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,650,585,068.95</u>	<u>3,992,412,692.37</u>

4.2 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,511,195,325.00	1,673,823,792.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,487,925.00	110,715,992.32
120	Нийтлэг татварын бус орлого	41,487,925.00	110,715,992.32
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,487,925.00	103,548,492.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,880,800.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,659,600.00	2,781,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	27,947,525.00	100,766,892.32
120009	Бусад орлого	00.00	7,167,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	360,000.00	1,563,107,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,469,347,400.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	360,000.00	1,563,107,800.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,563,107,800.00
133003	Хөрөнгийн	360,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,587,373,512.69	1,618,287,451.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,403,960,585.69	1,524,398,145.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,403,960,585.69	1,524,398,145.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	839,642,261.35	899,611,797.01
210101	Үндсэн цалин	467,871,908.02	544,921,326.51
210102	Нэмэгдэл	272,708,609.33	259,226,076.30
210104	Урамшуулал	83,589,044.00	81,354,072.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,472,700.00	14,110,322.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,374,023.67	106,302,844.41
210201	Тэтгэврийн даатгал	57,439,706.67	70,365,560.81
210202	Тэтгэмжийн даатгал	4,241,789.00	6,375,032.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,483,579.00	9,129,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,241,789.00	1,594,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,967,160.00	18,838,550.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	247,240,193.03	270,986,886.00
210301	Гэрэл, цахилгаан	15,308,493.00	20,000,000.00
210302	Түлш, халаалт	210,336,956.03	226,352,786.00
210303	Цэвэр, бохир ус	21,594,744.00	24,634,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,255,561.35	85,885,784.00
210401	Бичиг хэрэг	462,010.00	2,603,270.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	360,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	979,767.00	721,445.00
210404	Ном, хэвлэл	214,400.00	363,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,149,384.35	2,328,900.00
210408	Бараа материал ақталсны зардал	00.00	79,259,169.00
2105	Нормативт зардал	10,322,870.00	14,082,634.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	122,500.00	279,500.00
210502	Хоол, хүнс	9,732,070.00	11,900,334.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	468,300.00	1,902,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,124,872.00	26,031,800.00
210604	Урсгал засвар	27,124,872.00	26,031,800.00
2107	Томилолт, зочны зардал	687,100.00	1,099,156.00
210702	Дотоод албан томилолт	687,100.00	1,099,156.00

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,510,750.00	1,086,905.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,510,750.00	1,076,905.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	10,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	168,802,954.29	119,310,339.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	350,000.00	1,653,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,447,966.97	12,629,099.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	156,004,987.32	105,028,240.07
212	ТАТААС	00.00	4,644,900.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	4,644,900.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	4,644,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	183,412,927.00	89,244,406.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	171,669,282.00	83,425,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	67,700,400.00	56,491,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,147,082.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	74,221,800.00	26,934,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,600,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,743,645.00	5,818,606.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,743,645.00	5,818,606.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-76,178,187.69	55,536,340.33
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	131728333.04
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	131,728,333.04
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	00.00	131,728,333.04

4.3 АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,482,887,800.00	1,574,056,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,540,400.00	10,949,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,540,400.00	10,949,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,540,400.00	3,781,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,880,800.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,659,600.00	3,781,600.00
120009	Бусад орлого	00.00	7,167,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,469,347,400.00	1,563,107,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,469,347,400.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	1,563,107,800.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,563,107,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,482,887,800.00	1,573,657,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,482,887,800.00	1,573,657,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,298,121,555.00	1,475,360,893.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	848,396,370.00	891,207,702.50
210101	Үндсэн цалин	476,728,301.00	536,517,232.00
210102	Нэмэгдэл	272,606,325.00	259,226,076.30
210104	Урамшуулал	83,589,044.00	81,354,072.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,472,700.00	14,110,322.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,319,373.00	105,612,600.00
210201	Тэтгэврийн даатгал	59,385,056.00	67,729,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,241,789.00	6,375,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,483,579.00	9,129,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,241,789.00	1,594,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,967,160.00	20,783,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	256,903,237.00	250,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	15,308,493.00	20,000,000.00
210302	Түлш, халаалт	220,000,000.00	205,365,900.00
210303	Цэвэр, бохир ус	21,594,744.00	24,634,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,662,299.00	5,589,695.00
210401	Бичиг хэрэг	793,600.00	800,000.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	979,767.00	761,895.00
210404	Ном, хэвлэл	5,539,000.00	500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,899,932.00	2,877,800.00
2105	Нормативт зардал	15,146,584.00	17,602,578.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	180,000.00	279,500.00
210502	Хоол, хүнс	13,166,584.00	11,938,178.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	5,384,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,100,000.00	178,988,865.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	11,500,000.00
210604	Урсгал засвар	49,100,000.00	167,488,865.00
2107	Томилолт, зочны зардал	687,100.00	1,099,148.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00	1,499,905.00

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,499,905.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,406,592.00	23,760,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,170,000.00	1,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,236,592.00	22,360,400.00
212	ТАТААС	00.00	4,644,900.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	4,644,900.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	4,644,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	184,766,245.00	93,651,206.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	173,022,600.00	87,585,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	67,987,800.00	60,651,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,213,000.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	74,221,800.00	26,934,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,600,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,743,645.00	6,065,506.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,743,645.00	6,065,506.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	399,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	399,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	399,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	399,900.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	00.00	399,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-399,900.00

4.4 АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,362,808,149.51	538,372,286.69	-173,603,299.56	1,727,577,136.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,362,808,149.51	538,372,286.69	-173,603,299.56	1,727,577,136.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-76,178,187.69	-76,178,187.69
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,362,808,149.51	538,372,286.69	-250,892,107.25	1,650,288,328.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-110,810.00	-110,810.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,362,808,149.51	538,372,286.69	-251,002,917.25	1,650,177,518.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	2,202,334,410.13	00.00	2,202,334,410.13
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	214,890,000.00	00.00	-76,191,992.71	138,698,007.29
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,577,698,149.51	2,740,706,696.82	-327,194,909.96	3,991,209,936.37

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТГ

/ төгрөгөөр /

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,617,641,800.00	1,564,107,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,617,641,800.00	1,564,107,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,475,522,100.00	1,470,703,493.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	895,966,100.00	891,207,702.50
210101	Үндсэн цалин	524,910,700.00	536,517,232.00
210102	Нэмэгдэл	269,160,900.00	259,226,076.30
210104	Урамшуулал	86,421,800.00	81,354,072.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,472,700.00	14,110,322.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,612,600.00	105,612,600.00
210201	Тэтгэврийн даатгал	67,881,700.00	67,729,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,745,100.00	6,375,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,746,600.00	9,129,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,749,000.00	1,594,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,490,200.00	20,783,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	250,000,000.00	250,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	20,000,000.00	20,000,000.00
210302	Түлш, халаалт	205,365,900.00	205,365,900.00
210303	Цэвэр, бохир ус	24,634,100.00	24,634,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,787,200.00	4,787,195.00
210401	Бичиг хэрэг	800,000.00	800,000.00
210402	Тээвэр, шатахуун	400,000.00	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,000.00	761,895.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,737,200.00	2,075,300.00
2105	Нормативт зардал	14,039,300.00	14,017,678.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	280,000.00	279,500.00
210502	Хоол, хүнс	11,959,300.00	11,938,178.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	1,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	179,026,500.00	178,988,865.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,500,000.00	11,500,000.00
210604	Урсгал засвар	167,526,500.00	167,488,865.00
2107	Томилолт, зочны зардал	1,100,000.00	1,099,148.00
210702	Дотоод албан томилолт	1,100,000.00	1,099,148.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00	1,499,905.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,499,905.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23490400.00	23490400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.00	1,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,090,400.00	22,090,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142119700.00	87585700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	142,119,700.00	87,585,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	88,251,700.00	60,651,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	53,868,000.00	26,934,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	1,564,107,800.00

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын лаборатори нэгдүгээр сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	1,563,107,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	1,563,107,800.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,000,000.00